

БАНК БАЙГУУЛАХ ЗӨВШӨӨРЛИЙН НӨХЦӨЛ, ШААРДЛАГЫГ ТОГТООХ, ХЭРЭГЖҮҮЛЭХ ЖУРАМ

Нэг.Нийтлэг үндэслэл

1.1.Энэхүү журмын зорилго нь Банкны тухай хуулийн 20 дугаар зүйлийн 20.4 дэх хэсэг, Зөвшөөрлийн тухай хуулийн 8 дугаар бүлгийн 8.1, 8.2 дугаар зүйлийг үндэслэн Монголбанкнаас банк байгуулах зөвшөөрлийг олгох нөхцөл, шаардлагыг тогтоох, хэрэгжүүлэхтэй холбогдсон харилцааг зохицуулахад оршино.

1.2.Банкийг Банкны тухай хууль, Компанийн тухай хуулийн дагуу зөвхөн хаалттай хувьцаат компани хэлбэрээр үүсгэн байгуулж болно.

1.3.Банк байгуулах тухай Монголбанкны шийдвэрт өөрөөр заагаагүй бол банк байгуулах зөвшөөрлийг Банкны тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.1.1, 6.1.2, 6.1.3, 6.1.5, 6.1.8, 6.1.10-д заасан банкны үйл ажиллагааны зөвшөөрлийн хамт олгоно.

1.4.Банк нь байгуулагдсанаас хойш сүүлийн 6 сарын турш Банкны тухай хуулийн 16, 17 дугаар зүйлд заасан шаардлагыг хангаж байгаа нөхцөлд энэ журмын 1.3-д зааснаас бусад банкны эрхлэх үйл ажиллагааны зөвшөөрөл авах өргөдлийг Банкны тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.3-д заасан бүрдүүлбэрийн дагуу ирүүлж болно.

1.5.Банкны нэгж байгуулах, банкны хувь нийлүүлсэн хөрөнгийн хэмжээ, бүтцэд өөрчлөлт оруулах, шинээр хувьцаа, хувьцаанд хамаарах үнэт цаас гаргах, худалдах, шилжүүлэхэд тавигдах нөхцөл шаардлага, зөвшөөрөл олгох, олгосон зөвшөөрлийг хязгаарлах, түдгэлзүүлэх, хүчингүй болгохтой холбогдсон харилцааг Банкны тухай хуульд заасан журмаар зохицуулна.

1.6.Засгийн газрын шийдвэрээр банк үүсгэн байгуулах, банкны бүтцийн өөрчлөлтийн арга хэмжээний хүрээнд тусгай зориулалтын банк байгуулахад Банкны тухай хуулийн 19 дүгээр зүйлд заасан шаардлага хамаарахгүй.

1.7.Хөрөнгө оруулалтын төрөлжсөн банкны тухай хууль болон Банкны тухай хуулийн 22 дугаар зүйлийн дагуу банк байгуулах харилцааг хуульд өөрөөр заагаагүй бол энэ журмаар зохицуулахгүй.

1.8.Монголбанк нь Банкны тухай хууль тогтоомжийг үндэслэн банк байгуулах өргөдлийг энэ журмын дагуу хянаж, шаардлагатай тохиолдолд Монголбанкнаас газар дээр нь очиж баталгаажуулж болно.

1.9.Монголбанк Банкны тухай хуулийн 24 дүгээр зүйлд заасан үндэслэл тогтоогдвол энэ тухай өргөдөл гаргагчид ажлын 5 хоногийн дотор мэдэгдэнэ.

1.10.Энэхүү журмын дагуу үүсгэн байгуулах банкны нийт гаргасан хувьцаа, хувьцаанд хамаарах үнэт цаасны 50-иас дээш хувийг гадаад улсын банк эзэмшдэг бол тус банк (цаашид “гадаадын банк” гэх)-д Банкны тухай хуулийн 36.1 дэх хэсэг хамаарахгүй.

1.11.Зөвшөөрөл хүсэгч нь Монголбанканд ирүүлэх зөвшөөрлийн хүсэлтэд энэ журмын 2 дугаар зүйлд заасан нөхцөл, шаардлагыг хангах баримт бичиг, 3 дугаар зүйлд заасан өргөдөл, баримт бичгийг Монголбанкны Зөвшөөрлийн цахим системд оруулна.

Хоёр.Банк байгуулах зөвшөөрлийн нөхцөл, шаардлага

2.1.Банк үүсгэн байгуулагч, хувьцаа эзэмшигч нь дараах шаардлагыг хангасан байна:

2.1.1.тухайн улсын хууль тогтоомжийн дагуу татвар, санхүүгийн асуудал хариуцсан төрийн захиргааны байгууллагад орлого, санхүүгийн тайлангаа жилд нэгээс доошгүй удаа тайлагнадаг байх;

2.1.2.тухайн улсын хууль тогтоомжийн дагуу төрийн эрх бүхий байгууллагаас тухайн этгээдийн санхүүгийн үйл ажиллагаанд хяналт шалгалт хийдэг эсхүл хийх боломжтой байх;

2.1.3.хувьцаа эзэмшигч нь хуулийн этгээд бол санхүүгийн тайлан, мэдээгээ хараат бус хөндлөнгийн аудитын байгууллагаар жилд нэгээс доошгүй удаа баталгаажуулдаг байх;

2.1.4.банкны хувь нийлүүлсэн хөрөнгөд оруулах мөнгөн хөрөнгө нь тухайн этгээд, түүнтэй холбогдох этгээдийн санхүүгийн тайлангаар тодорхойлсон, хууль ёсны үйл ажиллагааны орлогоос бүрдсэн байх;

2.1.5.банкны нөлөө бүхий хувьцаа эзэмшигч нь Банкны тухай хуулийн 36 дугаар зүйлд заасан шаардлагыг хангасан байх;

2.2.Үүсгэн байгуулагчид (хувьцаа эзэмшигчдийн)-ын хурлаас сонгогдсон төлөөлөн удирдах зөвлөлийн дарга, гишүүд, гүйцэтгэх захирал нь Банкны тухай хуулийн 32, 33 болон 34 дүгээр зүйлд заасан холбогдох шаардлагыг хангасан байна.

2.3.Гадаадын банк үүсгэн байгуулахад дараах нэмэлт шаардлагыг хангасан байна:

2.3.1.Монгол Улсад банк байгуулахыг банк үүсгэн байгуулагч банкны харьяалагдах улсын хяналт шалгалтын эрх бүхий байгууллагаас зөвшөөрсөн байх;

2.3.2.Банкны тухай хуулийн 65 дугаар зүйлд заасан банкны нэгдэлд авах бүтцийн өөрчлөлтийн арга хэмжээг Монголбанк дангаар эсвэл банк үүсгэн байгуулагч банкны харьяалагдах улсын хяналт шалгалтын эрх бүхий байгууллагатай хамтран хэрэгжүүлэх боломжтой байх;

2.3.3.гадаадын банк нь Хөрөнгө оруулалтын тухай хуулийн 21.1-д заасан хуулийн этгээд бол хөрөнгө оруулалтын асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллага зөвшөөрсөн байх;

2.3.4.гадаадын банкны үүсгэн байгуулагч нь олон улсын аливаа хориг арга хэмжээний жагсаалтад ороогүй, эсхүл хориг арга хэмжээний жагсаалтад орсон улсад бүртгэлгүй байх.

Гурав.Банк байгуулах өргөдөл гаргахад бүрдүүлэх баримт бичиг

3.1.Банк үүсгэн байгуулагч нь банк байгуулахад шаардагдах баримт бичгийг дараах бүрдүүлбэрийн дагуу бэлтгэж, товьёг үйлдэн албан бичгээр Монголбанканд ирүүлнэ:

3.1.1.энэ журмын 1 дүгээр хавсралтад заасан маягтын дагуу гаргасан “Банк байгуулах зөвшөөрөл олгохыг хүссэн өргөдөл”;

3.1.2.өргөдөл гаргагчийг төлөөлөх эрх бүхий итгэмжлэгдсэн төлөөлөгчийг томилсон итгэмжлэл, түүнтэй адилтгах шийдвэр, тогтоол;

3.1.3.банк үүсгэн байгуулах гэрээ;

3.1.4.хуулийн этгээдийн бүртгэлийн асуудал эрхэлсэн төрийн захиргааны байгууллагаас авсан оноосон нэрийн баталгаажуулалтын хуудас;

3.1.5.Компанийн тухай хуулийн 14 дүгээр зүйлд нийцүүлэн зохион байгуулсан “Үүсгэн байгуулагчдын хурал”-ын тогтоол, тэмдэглэлийн хамт;

3.1.6.банкны дүрэм;

3.1.7.банкны удирдлага зохион байгуулалтын бүтэц;

3.1.8.банкны төлөөлөн удирдах зөвлөлийн гишүүдийг сонгосон шийдвэр;

3.1.9.энэ журмын 6 дугаар хавсралтын дагуу боловсруулсан “Банк байгуулах эдийн засгийн үндэслэл”;

3.1.10.Компанийн тухай хуулийн 13 дугаар зүйлийн 13.5-д заасан журмын дагуу хувьцаа эзэмшигч тус бүрийн хувьцаа худалдан авах тухай захиалгын хуудас, хувьцааны төлбөрийг төлөх огноо болон мөнгөн хөрөнгө байршиж буй харилцагч банкны тодорхойлолт, дансны хуулганы хамт;

3.1.11.Банкны тухай хуулийн 36 дугаар зүйлийн 36.11-д заасан журмын дагуу бүрдүүлсэн хувь нийлүүлэх хөрөнгийн эх үүсвэр, гарал үүслийг нотлох баримт;

3.1.12.энэ журмын 4 дүгээр хавсралтад заасны дагуу банкны техник, тоног төхөөрөмж программ хангамж, ажлын байрны тодорхойлолт;

3.1.13.гадаадын банк нь мөнгө угаах, терроризмыг санхүүжүүлэх үйл ажиллагаа, гэмт хэрэгт оролцож байгаагүй эсхүл ял шийтгэлийн хугацаа дууссаныг нотлох баримт бичиг;

3.2.Энэ журмын 3.1.6-д заасан Банкны дүрмийг Компанийн тухай хуулийн 16 дугаар зүйлийн 16.2, Банкны тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.3, 21 дүгээр зүйлийн 21.1, 31 дүгээр зүйлд заасан шаардлагыг хангаж, энэ журмын 5 дугаар хавсралтад заасан “Банкны дүрэм боловсруулах заавар”-ын дагуу боловсруулж баталсан байна.

3.3.Банкны төлөөлөн удирдах зөвлөлийн гишүүн, гүйцэтгэх удирдлага нь энэ журмын 3 дугаар хавсралтад заасан асуулгыг бөглөж, Банкны тухай хуулийн 32,33 болон 34 дүгээр зүйлд заасан шаардлагыг хангаж буй эсэх талаарх дараах нотлох баримтын хамт ирүүлнэ.

3.3.1.эзэмшсэн мэргэжил, боловсрол, мэргэшлийн зэрэг, эрхийг нотлох диплом, үнэмлэхийн хуулбар;

3.3.2.ажиллаж байсан болон ажиллаж байгаа байгууллагын тодорхойлолт, холбогдох шийдвэр, нийгмийн даатгалын шимтгэл төлөлтийн лавлагаа;

3.3.3.шүүхийн шийдвэрээр бусдад өр төлбөртэй эсэх тухай лавлагаа;

3.3.4.зээл, батлан даалт, баталгааны гэрээгээр хүлээсэн хугацаа хэтэрсэн аливаа өртэй эсэх лавлагаа;

3.3.5.эрүүгийн хариуцлага хүлээж байсан болон эрүүгийн хариуцлага хүлээж байгаа эсэх лавлагаа;

3.3.6.зөрчлийн улмаас татан буугдах үед тухайн банк санхүүгийн байгууллагад эрх бүхий албан тушаалтнаар ажиллаж байсан эсэх, талаарх Санхүүгийн зохицуулах хорооны тодорхойлолт;

3.3.7.санхүүгийн зах зээлд мэргэжлийн үйл ажиллагаа эрхэлдэг байгууллагын эрх бүхий албан тушаал эрхэлдэг бол сонирхлын зөрчлийг зохицуулсан нууцлалын гэрээ, холбогдох гэрээ, бусад нотлох баримт, зөрчлийн хэргээр хариуцлага хүлээж байсан эсэх тодорхойлолт;

3.3.8.аливаа хуулийн этгээдийн хувьцааг эзэмшдэг эсэх лавлагаа;

3.3.9.компанийн засаглалын сургалтад хамрагдсан гэрчилгээний хуулбар;

3.3.10.төлөөлөн удирдах зөвлөлийн гишүүн тус бүрээр энэ журмын 2 дугаар хавсралтад заасан “Банкны эрх бүхий албан тушаалтан этгээдийн тодорхойлолт”;

3.4.Төлөөлөн удирдах зөвлөлийн гишүүнээр сонгогдсон этгээд нь энэ журмын 3.3-д заасан шалгуур тус бүрийг хангаж байгааг шалган баталгаажуулсан үүсгэн байгуулагчид (хувьцаа эзэмшигчид)-ын хурлын дарга, хурал зохион байгуулах комиссын нарийн бичгийн дарга (цаашид Төлөөлөн удирдах зөвлөлийн нарийн бичгийн дарга)-ын гарын үсгээр баталгаажсан тодорхойлолт.

3.5.Энэ журмын 3.4-д заасан тодорхойлолтыг ирүүлсэн нь Банкны тухай хуулийн 32 дугаар зүйлийн 32.3-д заасан мэдэгдлийг Монголбанкнаас хүргүүлсэн гэж үзнэ.

3.6.Төлөөлөн удирдах зөвлөлийн аль нэг гишүүн Банкны тухай хуулийн 32, 33 болон 34 дүгээр зүйлд заасан шаардлагыг хангахгүй байгаа нь Монголбанкны хяналт шалгалтаар тогтоогдсон нөхцөлд Төлөөлөн удирдах зөвлөлийн хувьцаа эзэмшигчдийн ээлжит бус хурлыг зарлан хуралдуулахаас бусад бүрэн эрх дуусгавар болно.

3.7.Энэ журмын 3.1.3-д заасан бичиг баримт нь Компанийн тухай хуулийн 13 дугаар зүйлийн 13.4-д заасны дагуу банк үүсгэн байгуулах баримт бичиг хамаарахгүй.

3.8.Банк байгуулахтай холбоотой тогтоол, шийдвэр, төрийн захиргааны байгууллагаас гаргасан албан тоот тодорхойлолтыг эх хувиар нь холбогдох баримт, нотолгооны нотариатаар баталгаажуулсан хуулбар эсхүл төрийн цахим үйлчилгээний системээс дахин давтагдашгүй кодоор цахимаар баталгаажих боломжтой байх шаардлагыг хангасан байна.

3.9.Банк байгуулахтай холбоотой баримт бичиг, нотлох баримт нь гадаад хэл дээр үйлдэгдсэн бол эх хувийг нотариатаар баталгаажуулсан англи, монгол орчуулгын хамт ирүүлнэ.

3.10.Монголбанк нь банк байгуулахтай холбоотой асуудлаар нэмэлт материал шаардаж болох бөгөөд зөвхөн өргөдлийн бүрдүүлбэртэй холбоотойгоор эрх бүхий төрийн захиргааны байгууллагаас тодруулга, лавлагаа авч болно.

Дөрөв.Хяналт, хариуцлага

4.1.Банк байгуулах зөвшөөрөл авах өргөдөл гаргасантай холбоотой болон Банкны тухай хууль, энэ журмын 1.9-д заасны дагуу зөвшөөрөл олгохоос татгалзсан нь зөвшөөрөл хүссэн этгээдийн гаргасан аливаа зардлыг Монголбанк хариуцах үндэслэл болохгүй.

-oOo-

Банк байгуулах зөвшөөрлийн нөхцөл,
шаардлагыг тогтоох, хэрэгжүүлэх журмын 1 дүгээр хавсралт

..... БАНК БАЙГУУЛАХ

ЗӨВШӨӨРЛИЙН ӨРГӨДӨЛ

1. БАЙГУУЛАХ БАНКНЫ НЭР					
2. БАЙГУУЛАХ БАНКНЫ ХАЯГ					
3. ХУВЬ НИЙЛҮҮЛСЭН ХӨРӨНГӨ					
Хувь нийлүүлсэн хөрөнгийн хэмжээ (төгрөгөөр)					
Нэгж хувьцааны нэрлэсэн үнэ (төгрөгөөр)					
Хувьцааны тоо ширхэг					
4. БАНК ҮҮСГЭН БАЙГУУЛАГЧ, ХУВЬЦАА ЭЗЭМШИГЧИД					
	Оноосон нэр (овог, нэр)	Хувь нийлүүлсэн хөрөнгийн хэмжээ (төгрөгөөр)	Худалдаж авсан хувьцааны тоо ширхгээр хувиар		Нэгж хувьцааны үнэ (төгрөгөөр)
1					
2					
...					
о Дээрх хуулийн этгээд, иргэд нь хууль ёсны үйл ажиллагааны орлогоороо тус банкныг байгуулж байгаа болно.					
5. ТӨЛӨӨЛӨН УДИРДАХ ЗӨВЛӨЛ					
	Эрхлэх албан тушаал		Овог, нэр		
1	Хувьцаа эзэмшигчдийн хурлын дарга				
2	Төлөөлөн удирдах зөвлөлийн дарга				
3	Төлөөлөн удирдах зөвлөлийн гишүүн				
4	Төлөөлөн удирдах зөвлөлийн хараат бус гишүүн				
.					
о Дээрх иргэдийн ёс зүй, бизнесийн нэр хүнд нь банкныг удирдахад харилахгүй, банкны үйл ажиллагааг шударга, үр ашигтайгаар удирдах мэдлэг, чадвар, туршилагатай, банкны ашиг сонирхлыг хувийн ашигаас дээгүүр тавих ёс суртахууны төлөвшилттэй, ёс зүйн хэм хэмжээг сахиж ажиллах чадвартай, зээл, баталгаа, батлан даалтын гэрээгээр хүлээсэн аливаа хугацаа хэтэрсэн өргүй, шүүхийн шийдвэрээр гүйцэтгэх өр төлбөргүй, мөнгө угаах, терроризмыг санхүүжүүлэх үйл ажиллагаа, гэмт хэрэгт оролцоогүй, ял шийтгэлгүй гэдгийг судалж Банкны тухай хууль болон энэхүү журмын дагуу шаардлага хангасан гэж үзсэн тул эрх бүхий албан тушаалд томилсон болно.					
6. ГҮЙЦЭТГЭХ УДИРДЛАГА					
	Эрхлэх албан тушаал		Овог, нэр		
1					
2					
о Дээрх иргэдийн ёс зүй, бизнесийн нэр хүнд нь банкныг удирдахад харилахгүй, банкны үйл ажиллагааг шударга, үр ашигтайгаар удирдах мэдлэг, чадвар, туршилагатай, банкны					

ашиг сонирхлыг хувийн ашигаас дээгүүр тавих ёс суртахууны төлөвшилттэй, ёс зүйн хэм хэмжээг сахиж ажиллах чадвартай, зээл, баталгаа, батлан даалтын гэрээгээр хүлээсэн аливаа хугацаа хэтэрсэн өргүй, шүүхийн шийдвэрээр гүйцэтгэх өр төлбөргүй, мөнгө угаах, терроризмыг санхүүжүүлэх үйл ажиллагаа, гэмт хэрэгт оролцоогүй, ял шийтгэлгүй гэдгийг судалж Банкны тухай хууль болон энэхүү журмын дагуу шаардлага хангасан гэж үзсэн тул эрх бүхий албан тушаалд томилсон болно.

7. БАНК БАЙГУУЛАХ ӨРГӨДӨЛД ХАВСАРГАСАН БАРИМТ БИЧГИЙН ЖАГСААЛТ

1	
2	
3	
...	

Бүгд хуудас

о Дээрх баримт бичгүүдийг Банкны тухай хууль, Монголбанкны Ерөнхийлөгчийн 202.. оны дугаар тушаалаар батлагдсан "Банк байгуулах зөвшөөрлийн нөхцөл, шаардлагыг тогтоох, хэрэгжүүлэх журам"-ын дагуу үнэн зөв бүрдүүлсэн болно. Бүрдүүлсэн баримт бичигт аливаа худал ташаа, хуурамч мэдээлэл орсон тохиолдолд Банкны тухай хууль болон бусад хуулийн дагуу хариуцлага хүлээх болно.

8. ТӨЛӨӨЛӨХ ЭТГЭЭДИЙН МЭДЭЭЛЭЛ
о Хуулийн этгээд бол **о Иргэн бол**

Оноосон нэр (иргэн бол овог нэрээ бичнэ үү)	
Улсын бүртгэлийн дугаар	
Регистрийн дугаар	
Хаяг (иргэн бол оршин суугаа хаягаа бичнэ үү)	
Холбоо барих утас	

Банк байгуулах өргөдлийг холбогдох баримт бичгийн хамт хүлээн авч, хянан шийдвэрлэж, банк байгуулах зөвшөөрлийг олгоно уу.

Хавсралт. Дугаарласан . . . хуудастай.

БАНК БАЙГУУЛАХ ӨРГӨДӨЛ ГАРГАСАН:

Хуулийн этгээдийн

Гүйцэтгэх захирал

(гарын үсэг)

(нэр)

Банк үүсгэн байгуулагч нь

иргэн бол

(гарын үсэг)

(нэр)

Банк байгуулах зөвшөөрлийн нөхцөл,
шаардлагыг тогтоох, хэрэгжүүлэх журмын 2 дугаар хавсралт

..... банкны
эрх бүхий албан тушаалтны тодорхойлолт

ТОМИЛОГДОХ АЛБАН ТУШААЛ				
<i>(томилогдох албан тушаалын нэрийг энд бичнэ үү)</i>				
I.Товч танилцуулга				
Ургийн овог:		цээж зураг		
Овог:				
Нэр:				
Төрсөн огноо:				
Регистрийн дугаар:				
Иргэншил:				
Оршин суугаа хаяг:				
Цахим шуудангийн хаяг:				
Суурин болон гар утасны дугаар:				
II.Боловсрол <i>(боловсролын гэрчилгээнүүдийн нотариатаар гэрчлүүлсэн хуулбарыг хавсаргана уу)</i>				
Боловсрол	Эзэмшсэн боловсрол/ хамгаалсан цол	Суралцсан хугацаа	Сургуулийн нэр	Улс, хотын нэр
...				
...				
...				
III.Ажил эрхлэлт				
Одоо ажиллаж байгаа байгууллага				
Албан тушаалын нэр				
Албан тушаалд томилогдсон огноо				
Ажлын чиг үүрэг				
Ажлын хаяг, утасны дугаар				
Өмнөх хугацаанд ажилласан байгууллага	Албан тушаалын нэр	Ажлын чиг үүрэг	Албан тушаалд томилогдсон огноо	Ажлаас гарсан огноо, шалтгаан
...				
...				
...				
Хуулийн этгээдийн эрх бүхий албан тушаалтан бол доорх хүснэгтийг бөглөнө үү.				
д/д	Оноосон нэр, Бүртгэлтэй улсын нэр	Улсын бүртгэлийн дугаар	Регистрийн дугаар	

1			
2			
...			
Хуулийн этгээд, банкны хувьцааг шууд болон шууд бус хэлбэрээр эзэмшдэг бол доорх хүснэгтийг бөглөнө үү.			
	Оноосон нэр, Бүртгэлтэй улсын нэр	Эзэмшлийн хувь	Улсын бүртгэлийн дугаар, Регистрийн дугаар
1			
2			
...			
IV.Гэр бүлийн байдал (гэр бүлийн гишүүд, хамтран амьдрагчийн мэдээллийг оруулна уу)			
	Овог, нэр, Регистрийн дугаар	Таны юу болох	Одоо эрхэлж буй ажил, албан тушаал
1			
2			
...			
V.Харилцагч банк			
1			
2			
...			

Энэ журмын 3.3-д заасан нотлох баримтуудыг хавсаргав.

Хавсралт. Дугаарласан . . . хуудастай.
Тодорхойлолтыг үнэн зөв гаргасан болно.

(нэр)

(гарын үсэг)

..... оны сарын-ний өдөр

..... БАНКНЫ НӨЛӨӨ БҮХИЙ ХУВЬЦАА ЭЗЭМШИГЧ БОЛОХ ЭТГЭЭД,
БАНКНЫ ТӨЛӨӨЛӨН УДИРДАХ ЗӨВЛӨЛИЙН ДАРГА, ГИШҮҮН, БАНКНЫ
ГҮЙЦЭТГЭХ УДИРДЛАГАД ТОМИЛОГДОХ ЭТГЭЭДИЙН АСУУЛГА

1	Та өөр улсын эрх бүхий байгууллагад зөвшөөрөл авах өргөдөл гаргаж байсан уу? Таны өргөдлийг хүлээж аваагүй, эсвэл татгалзсан тохиолдол бий юу? Хэрэв тийм бол дэлгэрэнгүй мэдээлэл өгнө үү?	
2	Та аль нэг улсад иргэний, эрүүгийн шүүхийн шийдвэрээр ял, шийтгэл эдэлж байсан уу (18 нас хүрэхээс өмнө үйлдэж байсан гэмт хэрэг, тээврийн хэрэгсэл эзэмшихтэй холбоотой зөрчлийг хялбарчилсан журмаар шийдвэрлэсэн бол энд хамаарахгүй)? Хэрэв тийм бол дэлгэрэнгүй мэдээлэл өгнө үү.	
3	Санхүүгийн байгууллагатай холбоотой мөрдөн шалгах ажиллагаанд холбогдож байсан уу? Хэрэв тийм бол дэлгэрэнгүй мэдээллийг бичнэ үү.	
4	Та гишүүн байсан мэргэжлийн байгууллагын шийдвэрээр сахилгын хариуцлага хүлээж байсан уу? Тийм бол дэлгэрэнгүй мэдээллийг бичнэ үү.	
5	Та өмнө нь луйвар, залилан, эсвэл ижил төрлийн гэмт хэрэгтэй холбоотой байж болзошгүй орлогын талаар мэдүүлэг өгч байсан уу (хараат бус шинжээчээр ажиллаж байсан бол хамаарахгүй)? Хэрэв тийм бол дэлгэрэнгүй мэдээллийг бичнэ үү.	
6	Та, эсвэл таны хувьцаа эзэмшдэг, захирал, гүйцэтгэх удирдлага, мөн/эсвэл ажилтнаар нь ажилладаг, үйл ажиллагааг нь удирдан чиглүүлдэг байгууллага, нөхөрлөл нь төрийн, мэргэжлийн, эсвэл бусад төрлийн зохицуулагч байгууллагын зүгээс мөрдөн шалгах ажиллагаанд холбогдож байсан уу? Хэрэв тийм бол энэ талаар мэдээлэл өгнө үү.	
7	Таныг албан тушаалаас тань огцруулж байсан, эсвэл албан тушаалд томилогдохтой холбогдуулан татгалзаж байсан уу? Хэрэв тийм бол энэ талаар мэдээлэл өгнө үү.	
8	Таныг өөр улсад шүүхийн шийдвэрээр дампуурсанд тооцож байсан уу? Хэрэв тийм бол холбогдох мэдээллийг өгнө үү.	
9	Та өөр улсад шүүхийн шийдвэрээр төлбөр барагдуулах шийдвэрийг гүйцэтгэх боломжгүй болж байсан уу? Хэрэв тийм бол холбогдох мэдээллийг өгнө үү.	

10	Та хуулийн этгээд үүсгэн байгуулах, үйл ажиллагааг нь удирдан чиглүүлэхтэй холбоотой, эсвэл хуулийн этгээдийн удирдлага, ажилтны эсрэг залилан, эрх мэдлээ урвуулан ашиглах, бусад албан тушаалын гэмт хэрэгт холбогдон аль нэг улсад иргэний болон эрүүгийн хэрэг үүсгэгдэн шүүхийн байгууллагаар шийдвэрлэгдэж байсан уу? Хэрэв тийм бол дэлгэрэнгүй мэдээллийг өгнө үү.	
11	Таны удирдан чиглүүлж байсан, гүйцэтгэх удирдлагаар нь ажиллаж байсан, хувьцаа эзэмшиж байсан, эсвэл ажилтан нь байсан байгууллага, нөхөрлөл нь өр төлбөрөө бүхэлд нь, эсвэл хэсэгчлэн барагдуулж чадаагүй тохиолдол бий юу? Таныг албан тушаалаасаа чөлөөлөгдсөний дараа нэг жилийн дотор ийм тохиолдол гарсан уу? Тийм бол дэлгэрэнгүй мэдээллийг өгнө үү.	
12	Таны удирдан чиглүүлж байсан, гүйцэтгэх удирдлагаар нь ажиллаж байсан, хувьцаа эзэмшиж байсан, ажилтан нь байсан байгууллага, нөхөрлөл үйл ажиллагааны тусгай зөвшөөрлөө цуцлуулж байсан уу? Тийм бол дэлгэрэнгүй мэдээллийг өгнө үү.	
13	Та итгэлцэл, фидуци болон эдгээртэй адилтгах бусад төсөөтэй харилцааг тодорхой шалтгааны улмаас шаардсаны дагуу дуусгавар болгож байсан уу? Тийм бол дэлгэрэнгүй мэдээллийг өгнө үү.	
14	Та энэ байгууллагад хэн нэгэн гуравдагч этгээдийн удирдлага, зааварчилгааны дор ажиллах/ажиллаж байна уу? Хэрэв тийм бол дэлгэрэнгүй мэдээлэл өгнө үү.	
15	Та холбогдох хууль эрх зүй, зохицуулалтын болон мэргэжлийн стандарт шаардлагыг дагаж мөрдөхөд бэлэн үү?	

Би энэ тодорхойлолтыг гаргаснаар мэдүүлсэн бүх мэдээллийг үнэн зөв, бүрэн гүйцэд гэдгийг баталж байна. Мөн дээр дурдсан асуулгад мэдүүлсэн мэдээлэлд өөрчлөлт орох тохиолдолд банкаараа дамжуулан эрх бүхий байгууллагад 21 хоногийн дотор мэдэгдэнэ.

Би дээрх мэдүүлгийн эсрэг баримт нотолгоо гарч ирсэн, эсхүл санаатай худал мэдүүлсэн тохиолдолд Банкны тухай хууль, Зөрчлийн тухай хууль болон холбогдох бусад хуулийн дагуу хариуцлага хүлээх болно.

Овог, нэр _____ Гарын үсэг _____ Огноо _____

Банк байгуулах зөвшөөрлийн нөхцөл,
шаардлагыг тогтоох, хэрэгжүүлэх журмын 4 дүгээр хавсралт

..... БАНКНЫ ТЕХНИК, ТОНОГ ТӨХӨӨРӨМЖ, АЖЛЫН
БАЙРНЫ ТОДОРХОЙЛОЛТ

Банк нь үйл ажиллагаа эрхлэхэд шаардлагатай тоног төхөөрөмж, техник хэрэгслээр бүрэн хангагдсан бөгөөд үйл ажиллагаандаа (програм хангамжийн нэрийг бичнэ) програм хангамж ашиглаж, програм хангамж нь мэдээллийн нууцлал, найдвартай ажиллагааг хангасан болохыг баталж байна.

Банк нь үйл ажиллагаа эрхлэхэд зориулж Улаанбаатар хот (..... аймаг)-ын (хаяг) орших үл хөдлөх хөрөнгийг худалдан авсан (түрээсэлсэн) (аль нь болохыг доогуур нь зурах) бөгөөд энэхүү байр нь нийт. метр квадрат талбайтай, банкны үйл ажиллагаа эрхлэхэд тохиромжтой бөгөөд банкны аюулгүй ажиллагааг хангах харуул хамгаалалтын. компанитай болон дохиолол хамгаалалтын компанитай гэрээ байгуулахаар урьдчилан тохиролцсон болно.

Хавсралт:

- 1.Банкны үйл ажиллагаа эрхлэх үл хөдлөх хөрөнгийг худалдаж авсан бол үл хөдлөх хөрөнгийн бүртгэлийн гэрчилгээний нотариатаар гэрчлүүлсэн хуулбар, түрээсэлсэн бол түрээсийн гэрээ.
- 2.Банкны програм хангамжийг нийлүүлж байгаа этгээдтэй хийсэн гэрээ, уг програм нь банк болон харилцагчийн мэдээллийн нууцлал, аюулгүй байдлыг хангасан нотлох баримт, Монголбанкны банк хоорондын сүлжээ болон зээлийн мэдээллийн сантай холбогдох боломжтой байх.
- 3.Харуул хамгаалалтын болон дохиолол хяналтын компанитай гэрээ байгуулахаар урьдчилан тохирсон болохыг нотлох баримт.

ТӨЛӨӨЛӨН УДИРДАХ
ЗӨВЛӨЛИЙН ДАРГА

(гарын үсэг)

(нэр)

ГҮЙЦЭТГЭХ ЗАХИРАЛ

(гарын үсэг)

(нэр)

Банк байгуулах зөвшөөрлийн нөхцөл,
шаардлагыг тогтоох, хэрэгжүүлэх журмын 5 дугаар хавсралт

БАНКНЫ ДҮРЭМ БОЛОВСРУУЛАХ ЗААВАР

Банкны дүрэмд Банкны тухай хуулийн 21.1, Компанийн тухай хуулийн 16.2-т заасан шаардлагаас гадна дараах зүйлсийг тусгасан байна. Үүнд:

1. Банкны оноосон нэр, оршин байгаа газрын хаяг;
2. Өмчлөлийн болон байгуулагдсан хэлбэр;
3. Хувь нийлүүлсэн хөрөнгийн хэмжээ, бүтцэд өөрчлөлт оруулах нөхцөл;
4. Төлөөлөн удирдах зөвлөлөөс байгуулах хороо, тэдгээрийн гишүүдийг сонгох, чөлөөлөх журам, эрх, үүрэг, хариуцлага;
5. Банкны тухай хуулийн 33 дугаар зүйл, Монголбанкнаас баталсан Банкны Төлөөлөн удирдах зөвлөлийн хараат бус гишүүдийг нэр дэвшүүлэх, томилох, чөлөөлөх тухай журмын шаардлагыг хангасан Төлөөлөн удирдах зөвлөлийн хараат бус гишүүдийн эрх, үүрэг, хариуцлага;
6. Эрх бүхий албан тушаалтнуудын эрх, үүрэг, хариуцлага;
7. Их хэмжээний болон ашиг сонирхлын зөрчилтэй хэлцэл хийхэд баримтлах журам, энэ талаарх удирдлагын бүрэн эрх, үүрэг;
8. Дотоод аудитын газрын бүрэн эрх, үүрэг, хариуцлага;
9. Гүйцэтгэх удирдлагын бүрэн эрх, үүрэг, хариуцлага;
10. Банк, харилцагчийн нууцыг хамгаалах аюулгүй байдлыг хангахтай холбогдсон харилцааг тусгасан бодлого;
11. Хувьцааг арилжих, бусдад шилжүүлэх, харилцан хязгаарлалт хийхтэй холбоотой харилцааг зохицуулсан зохицуулалт;
12. Албадлагын арга хэмжээний хүрээнд банкнийг дахин хөрөнгөжүүлэх нөхцөлд хувьцаа эзэмшигчдийн эрхийн хязгаарлалтын тухай;
13. Холбогдох хууль тогтоомжийн дагуу санхүүгийн тайлан, их хэмжээний хэлцэл, ашиг сонирхлын зөрчилтэй хэлцлийн мэдээллийг олон нийтэд болон эрх бүхий байгууллагад мэдээлэл хүргүүлэх журам;
14. Банк татан буулгах үндэслэл, банкны удирдлагын буруутай үйл ажиллагаанаас харилцагчдад учруулсан хохирлыг барагдуулах арга хэлбэр, хариуцлага хүлээх зарчим;
15. Шаардлагатай гэж үзсэн бусад асуудал;

Банк байгуулах зөвшөөрлийн нөхцөл,
шаардлагыг тогтоох, хэрэгжүүлэх журмын 6 дугаар хавсралт

БАНК БАЙГУУЛАХ ЭДИЙН ЗАСГИЙН ҮНДЭСЛЭЛ БОЛОВСРУУЛАХ ЗААВАР

Банк байгуулах эдийн засгийн үндэслэлд дор дурдсан асуудлыг тусгана. Үүнд:

1. Улс орны эдийн засаг, банк санхүүгийн системийн өнөөгийн нөхцөл байдал, зах зээлийн багтаамж, цаашдын хандлага болон онцлогийг судалж, банкны системд шинэ банк байгуулах шаардлага болон шинэ банк байгуулагдсанаар үүсэх нөлөөллийн судалгааг эдийн засгийн үндэслэлтэй тооцоололд суурилан гүйцэтгэх.
2. Байгуулах банкны үйл ажиллагааны цар хүрээ, бүтээгдэхүүн үйлчилгээ, шинээр нэвтрүүлэх арга хэрэгсэл, техник технологийг тодорхойлж, банкны системд үзүүлэх нөлөөллийг тодорхой тусгах.
3. Банкны эхлэлтийн тайлан тэнцэл болон банк байгуулагдан үйл ажиллагаа эрхэлж эхлэхээс хойш хэрэгжүүлэх 3 жилийн хугацааны санхүүгийн төсөл, бизнес төлөвлөгөөг боловсруулах.
4. Байгуулах банкны эрхлэх үйл ажиллагааны чиглэл, ажил үйлчилгээ бизнес загвар ерөнхий нөхцөлийг тусгана.
5. Байгуулах банкны эрсдэлийг илрүүлэх, тооцох, хэмжих, үнэлэх, дүгнэх, удирдах арга хэрэгсэл болон дотоод хяналтын зохистой механизмыг хэрхэн бүрдүүлэхийг тодорхойлсон баримт бичиг боловсруулах.

Банкны бизнес төлөвлөгөө боловсруулах

Бизнес төлөвлөгөө нь тухайн банкны хэтийн хөгжил, зорилтыг тодорхойлж, энэ зорилтоо амжилттай биелүүлж, үр дүнд хүрэхийн тулд банкны бүтэц, зохион байгуулалт, эрхэлж буй ажил, үйлчилгээний шуурхай, найдвартай ажиллагаа, удирдлагын ур чадвар, банкны санхүү, төлбөрийн чадварын үзүүлэлт, үр ашгийг жил тутам сайжруулах чиглэлээр авч хэрэгжүүлэх арга хэмжээг тодорхой цаг хугацаагаар төлөвлөн боловсруулсан баримт бичиг юм.

Банк үүсгэн байгуулагч нь бизнес төлөвлөгөөг байгуулах банкны үйл ажиллагааны онцлогтой уялдуулан боловсруулах бөгөөд банк байгуулагдан үйл ажиллагаа эрхлэн явуулж эхэлснээс хойш 3 жилийн хугацаанд хэрэгжүүлэхээр төлөвлөсөн байна. Бизнес төлөвлөгөөнд тусгагдсан арга хэмжээ бүр нь тодорхой хугацаа, хариуцах эзэн, тайлбар, танилцуулгатай хийгдсэн байна.

Банкны бизнес төлөвлөгөөнд дараах асуудлуудыг тусгана Үүнд:

- 1. Банкны бизнесийн хэтийн төлөв, зорилт.** Энэ хэсэгт банкны үйл ажиллагаа эрхлэн явуулж эхэлснээс хойш 3 жилийн хугацаанд дараах асуудлын талаар баримтлах бодлого, байр суурийг он тус бүрээр төлөвлөж тусгана:
 - А. Банкны өмчлөл, үйл ажиллагааны хэлбэр, төрөл, ирээдүйн чиглэл, зах зээлд гүйцэтгэх үүрэг, эзлэх байр суурь, өрсөлдөгчид, цар хүрээ (нэгжийн тоо, байршил гэх мэт), харилцагчдын бүтэц, үйлчилгээний хөнгөн шуурхай болон итгэл найдвартай байдлыг бий болгох чиглэлээр нэвтрүүлэх ажил, үйлчилгээний шинэ арга хэлбэр, хэрэгсэл.
 - Б. Банкны актив, пассивын бүтэц, хэмжээ, зээл, хадгаламж, хүүгийн бодлого, зээлдэгчдийн бүтэц, тэдэнд хандах хандлага, тавих хяналтын арга хэлбэр.
 - В. Банкны онцлогтой уялдсан бусад арга хэмжээ.
- 2. Банкны бүтэц, зохион байгуулалт, түүнийг боловсронгуй болгох, удирдлагын ур чадварыг дээшлүүлэх талаар авах арга хэмжээ.** Энэ хэсэгт банкны үйл ажиллагаа

эрхлэн явуулж эхэлснээс хойш 3 жилийн хугацаанд дараах асуудлын талаар баримтлах бодлого, байр суурийг он тус бүрээр төлөвлөж тусгана:

- А. Тухайн банкны стратегийн зорилттой уялдсан бүтэц, зохион байгуулалт (банк нь актив пассивын хороо, зээлийн хороо, бүртгэл мэдээллийн, дотоод хяналтын болон чанаргүй зээлтэй ажиллах албыг заавал байгуулах шаардлагатай бөгөөд тухайн банкны цар хэмжээ, онцлог байдал, зайлшгүй шаардлагаас хамаарч удирдлагын бусад нэгжтэй байж болно), удирдлага, банкны үйл ажиллагаанд тавих хяналтын арга хэлбэр, шинэ хувь нийлүүлэгчидтэй харилцах харилцаа.
- Б. Зээл олголт, түүнд тавих хяналт, эргэж төлүүлэх үйл ажиллагаа.
- В. Банкны одоогийн эрхлэх үйл ажиллагаа болон ирээдүйд шинээр нэвтрүүлэх үйлчилгээний төрөл, хэрэгслийг зохицуулахад чиглэгдсэн бодлогын чанартай эрх зүйн баримт бичиг.
- Г. Хот болон орон нутагт өөрийн нэгжийг байгуулах эсэх, түүний байршил, бүтэц зохион байгуулалт.
- Д. Хүний нөөцийн байдал, ур чадвар.
- Е. Банкны үйл ажиллагааны онцлогтой уялдсан бусад арга хэмжээ.

3. Санхүүгийн төсөл. Энэ хэсэгт банкны үйл ажиллагаа эрхлэн явуулж эхэлснээс хойших 3 жилийн хугацааг хамруулан дараах санхүүгийн баримт бичгийн төслийг он тус бүрээр улирлын хуваарьтай тооцож төлөвлөхөөс гадна банкны жилийн төсвийг хийж тусгана:

- А. Банкны эхлэлтийн тайлан.
- Б. Үйл ажиллагаа явуулж эхэлснээс хойш улирал бүрийн тайлан тэнцэл, орлого зарлагын тайлан, мөнгөн хөрөнгийн урсгалын тайлангийн төсөөлөл.
- В. Ашиг, ашигт ажиллагааны түвшний үзүүлэлтүүдийн улирал бүрээр тооцсон төсөөлөл.

4. Санхүү, төлбөрийн чадварын талаарх 3 жилийн хугацааны төсөл. Энэ хэсэгт Банкны тухай хуулийн холбогдох заалтыг үндэслэн Монголбанкнаас тогтоосон дараах шалгуур үзүүлэлтүүдийг банкны үйл ажиллагаа эрхлэн явуулж эхэлснээс хойших 3 жилийн хугацаанд хэрхэн хангаж ажиллах талаарх төлөвлөгөөг он тус бүрээр улирлын хуваарьтай тооцож тусгана:

- А. Заавал байлгах нөөцийн хангалт.
- Б. Зээл, татан төвлөрүүлсэн хөрөнгийн харьцаа.
- В. Зээлийн багцын чанарын үзүүлэлт.
- Г. Эдийн засгийн нэг салбарт олгох зээл, нийт зээлийн өрийн үлдэгдлийн харьцаа.
- Д. Нэг зээлдэгч, холбогдох этгээдүүдэд олгох зээлийн дээд хэмжээ.
- Е. Өөрийн хөрөнгийн хүрэлцээ.
- Ё. Төлбөр түргэн гүйцэтгэх чадвар.
- Ж. Актив, пассивын эргэн төлөгдөх хугацааны зөрүү.
- З. Гадаад валютын позиц (нээлттэй буюу хаалттай).
- И. Эдийн засаг, санхүүгийн үзүүлэлтүүд.

5. Банк өөрийн үйл ажиллагааны онцлог эдийн засгийн нөхцөл байдлаас шалтгаалан үүсч болох эрсдэлийг даван туулах арга зам, банкийг дахин хөрөнгөжүүлэх боломжийг тусгасан банкны тогтворжуулах төлөвлөгөө.

Монголбанк нь банкны үйл ажиллагаанд хяналт шалгалт хийх бүр энэхүү бизнес төлөвлөгөөний биелэлтэд хяналт тавьж ажиллана.

